



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/145

Номгон

Аймгийн Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг
хангах дэд зөвлөлийн төлөвлөгөө батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл 9.4.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний бодлогын баримт бичгийг хангах хавсралтын заалтыг 20 дахь заалтыг тус тус үндэслэн заалтыг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Аймгийн хэмжээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөлөөс 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардалд 5.0 (таван сая) төгрөгийг хөгжлийн төлөвлөгөөний арга хэмжээний зардалаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

3.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа (Б.Мөнхбаяр)-т үүрэг болгосугай.


4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын ... дугаар
сарын 16-ны өдрийн ... дугаар захирамжийн



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ЗӨВЛӨЛӨӨС
2023 ОНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх ажил	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах байгууллага	Төсөв
1	Замын хөдөлгөөнийг зохион байгуулахтай холбоотой судалгаа шинэжилгээ хийж холбогдох байгууллагад санал танилцуулга хүргүүлэх	Замын хөдөлгөөнийг өөрчлөн зохион байгуулахтай холбоотой судалгаа 2 удаа хийж судалгаанд үндэслэн санал, танилцуулгыг дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.	Эхний хагас жилд	Замын цагдаагийн тасаг	-
2	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөнийг зохион байгуулах сургалтыг байгууллагын удирдлага, мэргэжилтэн, судлаач, хэрэглэгч нарын сургалтыг зохион байгуулах	Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөнийг зохион байгуулах сургалтыг 2-3 удаа зохион байгуулагдсан байна.	Жилдээ	Замын цагдаагийн тасаг	-
3	Сургууль, цэцэрлэгийн орчин болон ачаалал ихтэй гудамж, автозамын аюулгүй байдал хангах	Хөдөлгөөний эрчим ихтэй авто замаас тусгаарлах, хөдөлгөөнд оролцогчийн аюулгүй оролцох шилдэг модель, тэргүүний арга хэрэгслийг ашиглаж автозамын аюулгүй байдал хангасан байна.	Жилдээ	Замын цагдаагийн тасаг	-
4	Зам тээврийн осол замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчилд жил бүр судалгаа хийж ноцтой зам тээврийн осол түүний үр дагаварт нөлөөлж байгаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх компани т ажил зохион байгуулах	Ноцтой зам тээврийн осол, зөрчлийг бууруулах түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээ 2 удаа зохион байгуулсан байна.	6-9 сард	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөл	3.000.000

145

1	2	3	4	5	6
5	Хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой төрөл бүрийн уралдаан тэмцээнийг зохион байгуулах	Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах уралдаан тэмцээнийг 1 удаа зохион байгуулна	10-р сард	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөл, Замын цагдаагийн тасаг	2.000.000
6	Замын хөдөлгөөнд оролцогчийн хандлага, соёл, дадал, хариуцлагыг дээшлүүлэх	Мэдээлэл сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр 4-5 удаа зохион байгуулна.	Тогтмол	Замын цагдаагийн тасаг	-
7	Авто тээврийн салбарт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах даатгалын цогц систем бий болгох судалгааг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор хийх	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах даатгалын цогц систем бий болгох чиглэлээр хийгдэх судалгаанд дэмжлэг үзүүлэн ажилласан байна.	Тогтмол	Замын цагдаагийн тасаг	-
8	Улсын чанартай авто замд тээврийн хэрэгслийн хурдыг хянах хяналтын камер систем ашиглах	Улсын чанартай авто замд тээврийн хэрэгслийн дундаж хурдыг хянах хяналтын камер системийн ашиглалтыг нэмэгдүүлэх ажилд хамтран оролцож холбогдох санал, танилцуулгыг хүргүүлсэн байна.	3-р улиралд	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөл, Замын цагдаагийн тасаг	-
9	Хурдны теле хяналтын камерын системээр зөрчил илрүүлэх.	Дундаж хурдны теле хяналтын системээр хурд хэтрүүлэх зөрчлийг илрүүлж, зам тээврийн ослыг тодорхой хувиар бууруулсан байна.	Жилдээ	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөл, Замын цагдаагийн тасаг	-
10	Явган хүний гарцыг шилдэг техник технологи, инновацийн арга хэрэглэн тоноглох. Шөнийн харанхуй үед замын бусад хэсгээс илт ялгарах техникийн шийдлийг бий болгох	Явган хүний гарцыг шилдэг техник технологи, инновацийн арга хэрэглэн тоноглох харанхуй үед замын бусад хэсгээс илт ялгарах техникийн шийдлийг бий болгох үйл ажиллагаанд хамтран оролцоно.	Жилдээ	Замын цагдаагийн тасаг	-

1	2	3	4	5	6
11	Хамгаалах бүс, хамгаалалтын малгай болон бусад аюулгүйн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх	Хамгаалах бүс, хамгаалалтын малгай хэрэглээгүй зөрчилд тавих хяналт шалгалтыг эрчимжүүлж ажиллана.	Жилдээ	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөл,	-
12	Замын хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх, холбогдох судалгаан, шинжилгээ хийх замаар "хар цэг"-ийг тодорхойлж, ослын шалтгаан нөхцөлийг тогтоож, үр дагаврыг арилгах арга хэмжээнд оролцох.	"Хар цэг" –ийг тодорхойлж, осол гарах нөхцөлийг арилгах чиглэлээр зохион байгуулсан судалгаа, үйл ажиллагаанд хамтран ажилласан байна.	Жилдээ	Замын цагдаагийн тасаг	-
13	Иргэдийн оролцоотой замын хөдөлгөөний хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжин зөрчилд шийтгэл оногдуулж ажиллах.	E-Police цахим системд ашиглан замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг шийдвэрлэнэ.	Жилдээ	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөл, Замын цагдаагийн	-